



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 20 өдөр

Дугаар А/630

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай.


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2,3 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Батлан хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 17 дугаар зүйлийн 17.1.10, Засгийн газрын 2019 оны 200 дугаар тогтоол, Батлан хамгаалахын сайд аймгийн Засаг даргатай 2023 онд хамтран ажиллах гэрээний 2.9, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Зэвсэгт хүчний 186 дугаар ангид 2023 оны хоёрдугаар ээлжээр цэргийн жинхэнэ албанд татагдсан дайчдын цэргийн тангараг өргөх ёслолын ажиллагаанд оролцож, анги байгууллагын үйл ажиллагааг ард иргэдэд сурталчлан таниулах иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх зорилго бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүний зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

2. Зохион байгуулах үйл ажиллагааны зардалд 3,476,000 (Гурван сая дөрвөн зуун далан зургаан мянга) төгрөгийг аймгийн Засаг дарга дансны "Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөр арга хэмжээний зардал"-аас гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Улам-Өсөх)-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Базар)-д даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

Аймгийн Засаг даргын 2023 оны
12 дугаар сарын 20 ны өдрийн
А/хөдугаар захирамжийн хавсралт

ЦЭРЭГ ЭРГЭХ, ЦЭРГИЙН ТАНГАРАГ ӨРГӨХ ЁСЛОЛЫН
АЖИЛЛАГААНЫ ТӨСВИЙН ТООЦОО

Зорилго: Зэвсэгт хүчний анги байгууллагад алба хааж байгаа цэргийн ар гэрийн төлөөлөл, орон нутгийн удирдлагуудад цэргийн өдөр тутмын үйл ажиллагаа, цэргийн сургалт бэлтгэл явуулдаг орчин нөхцөлтэй танилцуулах замаар, Иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх.

Д/д	Явах чиглэл		ШТМ-ын зардал				
			Машины тоо	Явах км	Зарцуулах бензин	Нэг бүрийн үнэ	Нийт
1	Мөрөн-Эрдэнэт	Ланд 200	1	1000	200	4090	818,000
		Дунд оврын автобус	1	1000	200	4090	818,000
2	Уран бүтээлчдийн ажлын хөлс /хөгжимт драмын театрын уран бүтээлч 8 хүн		2 хоног			65000	1,040,000
3	Машин түрээс / Дунд оврын автобус 400.000/ 1 нэгж		2 хоног			400,000	800,000
4	Нийлбэр дүн						3,476,000

___оОо___